



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД
З.МЭНДСАЙХАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreatkhural@parliament.mn
http://www.parliament.mn

2021.10.26 № 40

Асуулт тавих тухай


Улсын Их Хурлын чуулганы 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн нэгдсэн хуралдаанд "Намрын ургац хураалт болон хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын талаар" Ерөнхий сайдын хийсэн мэдээлэлд "2021 онд газар тариалангийн салбарын ургац хураалт урьдчилсан байдлаар 594,1 мянган тонн үр тариа, үүнээс улаан буудай 559,2 мянган тоннд хүрэхээр байна." гэжээ. Цар тахлын улмаас гол нэрийн барааны хүнсний нөөц бүрдүүлэх хүрээнд 150 мянган тонн улаан буудайг 2021 оны хоёр, гуравдугаар сард ОХУ-аас импортлосноос үүдэн гурилын үйлдвэрүүд "агуулах сав дүүрэн" гэх шалтгаанаар тариаланчдын хураасан улаан буудайг авахгүй байх, үнийг зориуд бууруулах явдал гарч байгаа талаар тариаланчид гомдол гаргаж байна. Түүнчлэн энэ жил гурилын Улаан буудайн өөрийн өртгийг тодорхойлохдоо шатахуун, техник, тоног төхөөрөмж, сэлбэг, бордоо, ургамал хамгааллын бодисын үнийн өсөлтийг харгалзахгүй байгаа нь тариаланчдад алдагдал үүсгэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 39 дүгээр зүйлийн 39.1.2-т тус тус заасныг үндэслэн Танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:

1. 2021 оны улаан буудайн тариалалт, хураалтын явц, хураасан буудайг хадгалах сав, элеваторын багтаамж хүрэлцэх эсэх болон борлуулах, нөөцлөх асуудлаар ямар арга хэмжээ авч байгаа талаар;
2. Хөдөө аж ахуйг дэмжих сангийн үйл ажиллагаа, улаан буудайн үнэ тогтоож буй үндэслэл, үнийг тогтвортой байлгах талаар авч буй арга хэмжээ, холбогдох судалгаа, мэдээллийг дэлгэрэнгүй байдлаар;
3. Сэлэнгэ аймгийн зарим сумдад хур бороо ихтэй байсан учраас ургамлын болц гүйцэхгүй, ногоон тариа ихтэй, сортын онцлогоос хамаарч буудай налах, түүнчлэн цар тахлын үеэр оройтож тариалсан, ургалтын хугацаа хойшилсон зэрэг шалтгаануудаас ургац хураалтад хүндрэл үүссэн. Иймд Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй тариаланч, ногоочдыг дэмжсэн 3 хувийн хөнгөлттэй зээлийн эргэн төлөлтийг тодорхой хугацаагаар хойшлуулах зэрэг шаардлагатай арга хэмжээ авч байгаа эсэх талаар зэрэг болно.

Энэхүү асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39.8 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлэхийг хүсье.

Хувийг: Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт.
Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  Ч.УНДРАМ

2021000163